



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2014 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/М

Сэвхүүл

Г Архи согтууруулах ундааны Г
худалдаа, үйлчилгээний талаар авах
арга хэмжээний тухай

Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “л” дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Архи согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ эрхэлдэг газруудыг долоо хоног бүрийн “Баасан” гаригт сумын нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар нийтэд үйлчлэхгүй байхаар тогтоосугай.

2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилдэг цэгүүд энэхүү захирамжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгогдсон бүх аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /Ш.Буяннэмэх/, Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч /Ц.Батсайхан/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



В.БАТ-ЭРДЭНЭ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 1103

Сэвхүүл

Нийтийн их цэвэрлэгээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.7 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4, 8.5.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх бүх нийтийн их цэвэрлэгээг сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн 15:00 цаг, Бямба гарагийн 11:00 цагуудаас суманд үйл ажиллагаа явуулж буй бүх албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүд тогтмол зохион байгуулсугай.


2. Нийтийн их цэвэрлэгээний хуваарь болон албан байгууллага, аж ахуйн нэгжийн цэвэрлэгээ хийх талбайн хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

3. Өөрийн байгууллагынхаа хуваарьт газруудад цэвэрлэгээ хийлгэж ажилчдаа бүрэн хамруулан, ажлын үр дүнг тайлагнаж байхыг албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Сумын төвийн нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх нийтийн их цэвэрлэгээг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулахыг Байгаль хамгаалагч /М.ЖАРГАЛ/, 1, 2 дугаар багийн Засаг дарга /С.ЭНХЦЭЦЭГ/, /С.ОТГОНБААТАР/ нарт, хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч /Н.НАМУУНЦЭЦЭГ/-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулж ажиллахыг Засаг даргын орлогч /Ж.ЦЭВЭЭНДУЛАМ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



В.БАТ-ЭРДЭНЭ



1. Байгууллагуудын цэвэрлэгээ хийх хуваарьт талбай

1. "Шивээ-Овоо"ХК, "Шивээ-Сервис" ХХК, "Хаан" банк

- 1.1. ШОХК-ны конторын эргэн тойрон 100 м талбай
- 1.2. Орон сууцны 9,10-р байрнаас баруун тийш зам хүртэл, хойшоо төв талбай, урагшаа Бизнес хөгжлийн төв, зүүн тийш 12-р байр хүртэлх газар
- 1.3. Орон сууцны 13, 14, 15-р байрны эргэн тойрон, халаалтын зуухны орчин, баруун тийш 12-р байр хүртэл, зүүн тийш автогражийн зүүн тал хүртэл, хойд тал 100 метр гаазар
- 1.4. Бизнес хөгжлийн төв, спорт залны эргэн тойрон 100 метр газар
- 1.5. Төвийн болон урд автогражийн гадна орчны хааш хаашаа 100 метр газрын цэвэрлэгээ

2. "Нэгүн" ресторан, Супермаркет

Зүүн тийш 100 метр, хойшоо 8-р байр хүртэл, урагшаа төв талбайн урд талын өнцөг хүртэл

3. "Илчлэг Шивээ" ОНӨҮГ

Хойд тал чулуун хашааны гадна 100м, өөрийн хашааны дотор конторын орчин, урагшаа чулуун хашаа хүртэл, зүүн тийш сургуулийн хуучин чулуун хашаа хүртэл

4. 3-р Сургууль

Зүүн тийш 3-р цэцэрлэг, урагшаа эмнэлгийн чулуун хашаа, хойшоо 100 метр газар

5. Эрүүл мэндийн төв

Зүүн тал барилгын туурь хүртэл, урд тал өвсний складны баруун тал моргийн байшин, эмнэлгийн хуучин барилгын туурь, чулуун хашаа хүртэл хэсгийг хамарна.

6. ЗДТГ, Соёлын төв, Цахилгаан шугам сүлжээ, "Бүжинхэн" цэцэрлэг, "Бамбарууш" цэцэрлэг

6.1. Зүүн тал уурхайн спорт зал хүртэл, хойд тал Оргил худалдааны төв хүртэл, урд тал хуучин барилгын туурь хүртэл, баруун тал Говьгео ХХК-ны контор хүртэлх газар

6.2. Хашааны эргэн тойрон

7. Холбооны салбар, "Оюу" маркет, Төрийн банк, "Наран" худалдааны төв, Д.Оюунцэцэг, О.Долгормаа Т.Энхсаруул,

Өөрсдийн байрнаас урагш төв талбайн эргэн тойрон, хойш орон сууцны 6,7,8-р байр хүртэл, дэлгүүрүүдийн эргэн тойрон

8. “Хөгжил” ЗБН, “Тулга” цайны газар, Биллярд

Хойшоо төв талбай хүртэл, зүүн тийш 12-р байр хүртэл, өөрсдийн хашааны эргэн тойрон

9. СӨХ

Орон сууцны 3,6,7,8-р байрны орчны газар, 8-р байрнаас зүүн тийш 100 метр газар,

10. 3-р цэцэрлэг

Урагшаа улаан тоосгон барилга хүртэл, зүүн тийш орон сууцны 5-р байр, хойд талын зам хүртэл

11. “Оргил” худалдааны төв

Арын ногооны хашааны эргэн тойрон болон доторх талбай, зүүн тийш 100 метр газар

12. Цагдаагийн хэсэг

Зүүн тийш 4-р байр, баруун тийш 2-р байр хүртэл, хойшоо хөндлөн зам хүртэл

14. “НИК” ШТС, “Сод Монгол” ШТС

Эргэн тойрон 100 метр газар

15. Зүүн гэр хорооллын бүх айл өрхүүд өөрсдийн хашааны гаднах болон зүүн хогийг цэвэрлэх

Урд гэр хорооллын айл өрхүүд өөрсдийн хашааны гаднах орчныг цэвэрлэх

2. Эзэнгүй талбайн хог хаягдлыг цэвэрлэх хуваарь

1. Шивээ-Овоо ХК, Шивээ-Сервис ХХК

Шивээ-Овоо ХК-ийн конторын эргэн тойрон 200 метр газар

Орон сууцны 13, 14, 15-р байрны урд байрлах халаалтын зуухнаас урагш 200 метр, зүүн тийш 200 метр газар

2. ЗДТГ, Соёлын төв, Эрүүл мэндийн төв

ЗДТГ-аас баруун тийш 200 метр, урагш хуучин геологийн өлөнгийн цехийн барилгын туурь хүртэлх газар болон Цэцэрлэгт хүрээлэн

3. Илчлэг-Шивээ ОНӨҮГ, 3-р сургууль, 3-р цэцэрлэг, Цагдаагийн хэсэг

Өөрсдийн байгууллагаас хойш 200 метр, зүүн тийш зүүн гэр хороолол хүртэл

4. СӨХ

4, 8-р байрнаас зүүн тийш зүүн гэр хорооллын худаг хүртэл

Албан байгууллага, ААН, иргэдийн анхааралд

Нийтийн их цэвэрлэгээг тухайн сарын сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн 15 цагт бүх албан байгууллага, аж ахуйн нэгж өөрийн байгууллагын хуваарьт газруудад, Бямба гарагийн 11 цагт орон сууцны болон гэр хорооллын айл өрхүүд өөрийн хашаа болон байрныхаа эргэн тойрны газруудад тогтмол зохион байгуулна.

Мөн Бямба гарагийн 11 цагт албан байгууллагууд хуваарьтай эзэнгүй талбайг цэвэрлэх бөгөөд нийтийн их цэвэрлэгээнд хамрагдсан бүх албан байгууллага, аж ахуйн нэгж цэвэрлэгээ хийсэн мэдээгээ баримтжуулан албан бичгээр болон 89648585 утсаар өгнө.

Албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нар нийтийн их цэвэрлэгээнд ажилчдаа бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж шаардлагатай багаж хэрэгслээр хангаж ажиллана.

Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийн дагуу албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдийг цэвэрлэсэн хог хаягдлаа шатаахыг хориглох бөгөөд тухайн өдөр ЗДТГ-аас хог тээврийн машинаар хогийг ачих болохыг анхааруулж байна.

Их цэвэрлэгээнд хамрагдаагүй албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль Захиргааны хариуцлагын тухай хуули йн дагуу Байгаль орчны хяналтын улсын байцаагч хариуцлага хүлээлгэх болно.

Засаг даргын Тамгын газар

Сумын Засаг даргын 2015 оны тоот захирамжийн 1-р хавсралт



2015 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ХУВААРЬ

Өдөр	Сар											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1												
2												
3												
4												
5												
6												
7												
8												
9												
10												
11												
12												
13		■										
14		■										
15												
16												
17												
18												
19												
20												
21												
22												
23												
24				■			■					
25				■			■		■			■
26						■			■			■
27			■			■					■	
28			■					■			■	
29					■			■				
30	■				■					■		
31	■									■		

Жич: Нийтийн их цэвэрлэгээний хуваарьт тодорхой шалтгаанаар өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр мэдэгдэнэ.